



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Өргөн Нэвтрүүлгийн Зохицуулалтын Газар

“ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖИЙГ
ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ”

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2021 он

**“ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖИЙГ
ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ”
зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар**

Агуулга:

1. Судалгааны аргачлал боловсруулах зорилго _ хуудас 3-4
2. Судалгааны аргачлалын хамрах хүрээ _ хуудас 4-6
3. Зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэл, хугацаа, тайлан _хуудас 6-8
4. Зөвлөхөд тавигдах шаардлага _хуудас 8-9

1. Судалгааны аргачлал боловсруулах зорилго

Харилцаа холбооны зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн (радио, телевиз, олон суваг дамжуулах, газрын сүлжээний) үйлчилгээ эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажилладаг.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн үндэс, харилцааг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар тодорхойлж зохицуулсан бөгөөд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулж олгохоор хуульд заасан. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдахаас өмнө өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус хороонд ирүүлсэн хүсэлтэд үндэслэн үнэлгээ, дүгнэлт гаргах зарчмаар олгох эсэхийг хорооны хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлдэг байсан бол харин хууль батлагдсанаар нээлттэйгээр сонгон шалгаруулах шаардлага үүссэний зэрэгцээ хаана (хамрах хүрээ), хэнд (ямар шалгуур хангасан байх), хэдийг олгох зэрэг асуултад хариулт өгөх шаардлага бий болсон.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгоход баримтлах үндсэн зарчмыг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.1-т “... тусгай зөвшөөрөл олгоходоо ... өргөн нэвтрүүлгийн талаар төрөөс баримталж байгаа бодлого, харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн хөгжлийн ирээдүйн чиг хандлага, техник, технологийн дэвшил, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, эрх ашигт нийцүүлэн зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх”, 7.4.2-т “ ... өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэх” гэж тус тус тодорхойлсон бөгөөд тусгай зөвшөөрөл олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээг судалгаанд үндэслэж тогтоохоор зохицуулсан.

Судалгааны аргачлал боловсруулах зорилго

Өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаар судалгаа хийх аргачлал боловсруулах **зорилго** нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос сонгон шалгаруулалт зарлах өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл, тоо, хамрах хүрээг тогтооход шаардлагатай үзүүлэлтүүдийг өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, өрсөлдөөний нөхцөл байдалтай уялдуулан тодорхойлох, өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, өрсөлдөөний нөхцөл байдлыг авч үзэх судалгааны үндсэн үзүүлэлт, аргачлалыг гаргахад оршиж байгаа юм. Энэхүү аргачлалын дагуу хийсэн судалгааны дүнд үндэслэн нээлттэй сонгон шалгаруулалт зарлах үйлчилгээний төрөл, тоо, хамрах хүрээг тодорхойлох юм.

Зохицуулах хорооноос Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т “өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж, жил бүр үнэлэлт, дүгнэлт гаргах” гэж заасныг үндэслэн энэхүү судалгааг жил бүр гаргаж, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний өрсөлдөөний нөхцөл байдал, үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд үнэлэлт, дүгнэлт өгөхөөр ажиллаж байна.

Энэхүү судалгаа хийх аргачлал боловсруулах ажлын хүрээнд радио, телевиз, олон суваг дамжуулах, газрын сүлжээний үйлчилгээг тухайн орон нутаг, хамрах хүрээнд шинээр эрхлэхэд зах зээлийн орон зай байгаа эсэх, зах зээлд зохистой байдлаар оршин тогтнох боломжтой эсэх зэрэг шалгуур үзүүлэлт, нөлөөллийг тодорхой болгох шаардлагатай бөгөөд хүн амын тоо, нягтрал, үйлчилгээг хүлээн авч байгаа байдал, хэрэглээг мөн харгалзан үзэх нь зүйтэй юм. Иймд судалгааны аргачлал боловсруулахад дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна:

- өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамжийг тодорхойлох үндсэн шалгуур үзүүлэлтүүд, авч үзэх шаардлагатай хүчин зүйлсийг үндэслэлтэй тодорхойлох;
- зах зээлийн багтаамжийг тодорхойлох судалгаа хийхдээ өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс жил бүр авдаг статистик, тоон мэдээлэл, салбарын зах зээлийн мэдээлэл болон хүн ам, өрхийн тоо, нягтрал зэрэг статистик үзүүлэлтүүдэд хэрхэн үндэслэх, уялдаа холбоог хангах;
- өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухайн төрлөөр үйлчилгээ эрхлэх зохистой тоо хэмжээг хэрхэн, ямар үзүүлэлтүүдтэй уялдуулан авч үзэх, үнэлэлт дүгнэлт гаргахад авч үзэх бусад үзүүлэлтүүдийг тодорхойлох;
- зах зээлийн багтаамжийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг авч үзэхдээ медиа зах зээл ялангуяа өргөн нэвтрүүлгийн онцлогийг харгалзан үзэх;
- зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг үйлчилгээний төрөл бүрд хэрхэн тооцож авч үзэх, зах зээл дээрх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн тоотой хэрхэн уялдах, төвлөрлийг хэрхэн тооцох, уялдаа холбоог хангах;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль тогтоомжтой уялдуулан авч үзэх гм.

2. Судалгааны аргачлал боловсруулахад анхаарах асуудал, хамрах хүрээ

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан нээлттэй сонгон шалгаруулах зарчмаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл (хүснэгт-1)-д тодорхойлсон үйлчилгээ нь зах зээлийн зорилтот бүлэг, хэрэглээ, орлогын эх үүсвэр, зах зээлд эзлэх хувь хэмжээ, хэрэглэгчдэд хүрэх стратеги болон бизнес төлөвлөлт, бизнес модель зэргээс хамааран өөр хоорондоо ялгаатай байх тул судалгааны аргачлал боловсруулах хамрах хүрээг тухайн үйлчилгээний төрөл тус бүрээр тодорхойлох хэрэгцээ байна.

Хүснэгт-1

№	Үйлчилгээний төрөл	Хамрах хүрээ	
		Улаанбаатар хотод	Аймаг, сум-нд
1	Телевиз: - өргөн нэвтрүүлгийн телевиз - арилжааны телевиз	Аргачлалд тухайн зах зээл, үйлчилгээний онцлог шинж, төрөөс баримтлах бодлого гм анхаарч үзэх	
2	Арилжааны радио		
3	Олон суваг дамжуулах үйлчилгээ		

4	Газрын сүлжээний үйлчилгээ	
---	----------------------------	--

Тухайлбал радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээний хувьд хэрэглэгчид үнэ төлбөргүй хүрэх үйлчилгээ байдаг бол олон суваг дамжуулах үйлчилгээ нь хэрэглэгчид гэрээний үндсэн дээр хүрдэг төлбөртэй үйлчилгээ байна. Харин радио, телевизийн хувьд хэрэглэгчээс орлого төвлөрүүлэх боломжгүй, зар сурталчилгааны орлогоос санхүүждэг үйлчилгээ бөгөөд хэрэглэгч тухайн радио, телевизийн хөтөлбөрийг хүлээн авч сонсож, үзэж байгаа эсэхийг шууд тогтоох боломжгүй, зөвхөн түүвэр судалгаагаар гаргах боломжтой байдаг зэрэг онцлог шинжүүдтэй байна. Түүнчлэн телевизийн үйлчилгээний зах зээл нь радиогийн зах зээлээс ялгаатай байдаг тул радио болон телевизийн зах зээлийг тус тусад нь авч үзэх шаардлагатай байдаг. Харин радио, телевиз нь дотроо арилжааны, өргөн нэвтрүүлгийн, төлбөртэй гэх зэргээр үйлчилгээний төрөлд хуваагддаг ба эдгээр үйлчилгээнд бодлого, зохицуулалтын ялгаатай нөхцөл, шаардлагууд тавигддаг тул зах зээлийг тус тусад нь авч үзэх шаардлагатай байдаг.

Хамрах хүрээ

Улаанбаатар хотод нийтдээ 60 арилжааны телевиз, 18 өргөн нэвтрүүлгийн телевиз тусгай зөвшөөрөлтэй байгаа бол орон нутагт 9 арилжааны телевиз, 56 өргөн нэвтрүүлгийн телевиз тус тус тусгай зөвшөөрөлтэй байна. Радиогийн үйлчилгээний хувьд Улаанбаатар хотод 33, орон нутагт 26 радио тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байна. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдахаас өмнө радио, телевизийн үйлчилгээ эрхлэх хүсэлтийн дагуу Зохицуулах хороо нь жилд дунджаар 5-8 (УБ хот, орон нутаг нийлээд) тусгай зөвшөөрөл олгож ирсэн байдаг. Радио, телевизийн үйлчилгээ эрхлэх хүсэлтийн тоо жилд дунджаар 10-15 орчим бүртгэгдэн ирдэг ба Зохицуулах хорооны ажлын албанаас тусгай зөвшөөрлийн хүсэлтийн материалд үнэлгээ дүгнэлт гаргаж, шаардлага хангасан этгээдийн хүсэлтийн дагуу тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг гаргаж ирсэн.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо сүүлийн жилүүдэд техник технологийн дэвшил, тоон технологийн шилжилт, хэрэглэгчийн үйлчилгээ, бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл, сонголт, өрсөлдөөний нөхцөл байдал зэргээс шалтгаалан орон нутагт буурч байгаа хэдий ч Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчид орон нутагт хамрах хүрээ өргөжүүлж үйлчилгээ хүргэх, хэрэглэгч татах зэргээр орон нутгийн зах зээлд давамгайл байдал тогтоож, зах зээлд төвлөрөл үүсэх хандлага ажиглагдаж байна. Зохицуулах хорооны тоон мэдээллээр Улаанбаатар хотод 2016 онд хамгийн сүүлд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол орон нутагт 2018 онд 2 (Баян-Өлгий, Өвөрхангай аймаг), 2019 онд 2 (Өвөрхангай, Орхон аймаг) тусгай зөвшөөрөл тус тус олгогдсон байна.

Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч 2 этгээд байгаагийн нэг нь улсын төсөвт үйлдвэрийн газар болох Радио, телевизийн

сүлжээ УТҮГ (2006 он) бол нөгөө нь 2019 онд тоон радиогийн газрын сүлжээний тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байна.

Зохицуулах хорооны тоон мэдээллээр радио, телевизийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ байнгын өсөн нэмэгдэж байсан бөгөөд сүүлийн 5 жилийн дунджаар жилд 2-3 өргөн нэвтрүүлгийн телевизийн, 5-6 арилжааны телевизийн, 3-4 радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл, тусгай зөвшөөрлийн ангилалын дагуу зөвлөх үйлчилгээний хүрээнд гүйцэтгэх судалгааны аргачлал боловсруулах ажлыг дараах үйлчилгээ тус бүрийн онцлог, бодлого, зохицуулалтын чиглэлийг харгалзан нийтлэг байдлаар тодорхойлох шаардлагатай байна:

1. Өргөн нэвтрүүлгийн телевиз
2. Арилжааны телевиз
3. Арилжааны радио
4. Олон суваг дамжуулах үйлчилгээ
5. Газрын сүлжээний үйлчилгээ

Иймээс Зохицуулах хорооны зүгээс энэхүү судалгааны аргачлал боловсруулах ажлын хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамжийг тодорхойлох **нийтлэг шалгуур үзүүлэлт, ерөнхий аргачлалыг** эхний ээлжинд тодорхой болгох шаардлагатай гэж үзэж энэхүү ажлын даалгаврыг боловсруулсан бөгөөд цаашдаа үйлчилгээний төрөл, хамрах хүрээ тус бүрээр шалгуур үзүүлэлтийг нарийвчлан задлах, аргачлалыг дэлгэрүүлэх, тодорхойлох ажлыг үе шаттай хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Ингэж үе шаттай хэрэгжүүлэх нь судалгааны аргачлалын хамрах хүрээг тодорхой болгох, ажлын үр дүнг хэмжигдэхүйц болгохоос гадна аргачлалыг үйлчилгээ тус бүрээр нарийвчлан гаргах нөхцөл бүрдэнэ.

3. Зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэл, хугацаа, тайлан

Судалгааны аргачлал боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэлийн үр дүнд дараах ажлыг хийж хүлээлгэн өгсөн байна. Үүнд:

1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, өрсөлдөөний орчин, багтаамж, өсөлт, бууралтын динамик, чиг хандлага, хэрэглээг өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл бүрийг харгалзан тодорхойлох шалгуур үзүүлэлт, ашиглах салбарын статистик үзүүлэлт, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо зэрэг үнэлэлт дүгнэлт гаргахад шаардлагатай ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТОДОРХОЙ БОЛГОХ;
2. Үндсэн үзүүлэлтүүдийн хоорондын харилцан хамаарал, зүй тогтлыг тодорхой болгох ТАЛААР ЗААВАР ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙХ;
3. Судалгааны аргачлалын математик загвар, томъёолол, ТООЦООЛЛЫН ЖИШИГ-ЗАГВАР, excel загвар гаргах;

4. Энэхүү жагсаалтын 1-3-т заасан мэдээллийг багтаасан судалгааны аргачлалын заавар, тайлбар, зөвлөмж, дүгнэлт бүхий СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ-ын баримт бичиг боловсруулна.

Зохион байгуулалт

Зөвлөх нь зах зээлийн судалгаа хийх, түүвэр судалгаа хийх, үр дүнг нэгтгэх, боловсруулалт хийх, харьцуулан судлах, орчны шинжилгээ хийх, аналитик дүгнэлт, тайлан, зөвлөмж гаргах, баримт бичиг боловсруулах туршлагатай байх шаардлагатай.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь судалгаа хийхэд шаардлагатай үйлчилгээний зохицуулалт, салбарын онцлог үйл ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, салбарын холбогдох байгууллагуудад судалгаатай холбогдох мэдээлэл, тоот хүргүүлэх, дэмжлэг үзүүлж болох бөгөөд зөвлөх үйлчилгээний явцад хяналт тавьж ажиллана.

Ажил гүйцэтгэх хугацаа

Зөвлөх үйлчилгээг **90 хоногийн** хугацаанд гүйцэтгэх бөгөөд ажил гүйцэтгэх хугацааны хуваарийн дагуу гэрээнд заасан хоногт багтаан боловсруулж ирүүлнэ.

Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх хугацааг шаардлагатай гэж үзвэл зөвлөхтэй харилцан тохиролцож сунгаж болно.

Тайлагнах үе шат, тайлан ирүүлэх удирдамж

Зөвлөх нь судалгааны аргачлал боловсруулах ажлын хүрээнд гүйцэтгэх ажлуудыг тодорхойлж, захиалагчийн саналыг тусгасан ажлын төлөвлөгөөг зөвлөх үйлчилгээний гэрээнд хавсаргана.

Ажлын тайланг дараах байдлаар ангилан ирүүлэх ба заасан хугацааны хуваарийг мөрдөнө.

- Үндсэн үзүүлэлт, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал, зүй тогтлын талаар өгсөн заавар зөвлөмж, судалгааны аргачлалын математик загвар, тооцооллын жишиг-загварыг гаргаж гэрээ байгуулснаас хойш **60 хоногийн** дотор ирүүлнэ.
Захиалагчийн зүгээс ирүүлсэн мэдээлэл, загварыг шалгаж, зөвлөх үйлчилгээний явцтай танилцаж, ажлын даалгаврын хүрээнд нэмэлт тайлбар өгөх, судалгаа хийхэд анхаарах зүйлс, эцэслэн хүлээн авахад оруулах шаардлагатай гэж үзсэн асуудал саналыг нэгтгэн зөвлөхтэй уулзалт ярилцлагыг баримт бичиг ирүүлснээс хойш ажлын 5-8 хоногийн дотор хийж, санал шүүмжлэл, зөвлөмжийг хүргүүлнэ. Жич: Захиалагчаас санал нэгтгэн хүргүүлэх хугацааг гэрээ дуусгавар болгох хугацаанд хамааруулж тооцохгүй.
- Судалгааны аргачлалын талаарх заавар, тайлбар, зөвлөмж, дүгнэлт, нэгтгэл бүхий баримт бичийг захиалагчаас үндсэн үзүүлэлт, математик загвар, заавар зөвлөмж, тооцооллын жишиг-т өгсөн санал, зөвлөмж, төсөлд

нэмэлтээр оруулахаар заасан өөрчлөлтүүдийг бүрэн гүйцэт тусгаж, санал, зөвлөмжийг хүлээн авсан өдрөөс хойш **21 хоногийн** дотор ирүүлнэ.

Захиалагч талаас ажлын даалгаврын хүрээнд нэмж сайжруулах, СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛЫН БАРИМТ БИЧИГТ тодруулах, тодорхой өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд саналыг нэгтгэн ажлын 5-8 хоногт багтаан хүргүүлэх бөгөөд ЭЦСИЙН БАЙДЛААР дахин САЙЖРУУЛАН, өгсөн санал зөвлөмжийг тусгаж, санал зөвлөмжийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор эцэслэн ирүүлнэ. Жич. Захиалагчаас санал нэгтгэн хүргүүлэх хугацааг гэрээ дуусгавар болгох хугацаанд хамааруулж тооцохгүй.

Зөвлөх үйлчилгээний тайланг гэрээнд заасан хугацаанд багтаан захиалагч талд цаасан болон электрон хэлбэрээр, холбогдох судалгаа, дата мэдээлэл, файлын хамт хүлээлгэн өгнө.

Төлбөрийн нөхцөл

Ажлын хөлсийг үр дүнд үндэслэсэн хэлбэрээр, гэрээнд заасны дагуу ажлын даалгаврын гүйцэтгэлээр хэсэгчлэн дараах байдлаар төлнө.

1. Гэрээний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх дүнг ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТОМЬЁОЛОЛ, МАТЕМАТИК ЗАГВАРЧЛАЛ, ЗААВАР ЗӨВЛӨМЖ, ТООЦООЛЛЫН ЖИШИГ-ЗАГВАР ирүүлсний дараа төлнө. Ажлын хэсгийн зүгээс мэдээлэл, загварын иж бүрдлийг шалгаж, танилцаж /ажлын 5 хоног/ ажлын даалгаварт заасан шаардлагыг хангасан гэж үзсэн тохиолдолд холбогдох хөлсийг олгоно.
2. Гэрээний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх дүнг СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛЫН БАРИМТ БИЧИГ ирүүлсний дараа төлнө. Ажлын хэсгийн зүгээс баримт бичгийн иж бүрдлийг шалгах, баримт бичигтэй танилцаж /ажлын 5 хоног/ ажлын даалгаварт заасан шаардлагыг хангасан гэж үзсэн тохиолдолд холбогдох хөлсийг олгоно.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох бүх зардал, татвар зэрэг багтсан байна.

4. Зөвлөхөд тавигдах шаардлага

Зөвлөх нь хамгийн багадаа дараах шаардлага хангасан, мэдлэг, чадвар, туршлагатай байх ба гэрээнд заасан ажил үүргийг хугацаанд нь чанартай гүйцэтгэх чадвартай байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээг зах зээл, эдийн засаг, зах зээлийн өрсөлдөөн, бизнес төлөвлөтийн чиглэлээр мэдлэг, туршлагатай, мэргэшсэн, судалгаа, шинжилгээ хийх чадвартай, түүвэр судалгаа хийх, асуулга боловсруулах, үр дүнг нэгтгэх, боловсруулалт хийх, харьцуулан судлах, орчны шинжилгээ хийх, аналитик дүгнэлт, зөвлөмж тайлан гаргах, баримт бичиг боловсруулах туршлагатай зөвлөх гүйцэтгэх ба дараах ерөнхий шаардлага хангасан байна. Үүнд:

- Зах зээлийн судалгаа хийж байсан туршлагатай байх;

- Санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага, менежментийн чиглэлийн мэргэжилтэй байх;
- Түүвэр судалгаа хийх, асуулга боловсруулах, дата боловсруулалт хийх, үр дүнг нэгтгэх, харьцуулан судлах, нөлөөллийн шинжилгээ хийх, судалгаа шинжилгээ хийх туршлагатай байх;
- Бизнес төлөвлөлт, стратеги, бодлого боловсруулах, дүн шинжилгээ хийх, аналитик дүгнэлт, зөвлөмж гаргах, баримт бичиг боловсруулах, тайлагнах ур чадвартай байх;
- Хувийн зохион байгуулалт сайтай ба багаар ажиллах чадвартай;
- Монгол, Англи хэлний бичгийн ур чадвар сайтай байх.

Жич: Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр ерөнхий агуулга, ажлын хүрээнд зарим нэг өөрчлөлтийг энэхүү удирдамжид оруулж болно.

--ooOoo--